



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/286

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт төсөвт  
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын 2.1.3, Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 05 дүгээр сарын 23-ны өдийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж аймгийн Засаг дарга, Цахим хөгжил харилцаа холбооны сайдтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний 2.3.17, 2.3.18 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хурдан” төвийн нээлтийн болон засвар үйлчилгээ хийх зардалд 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Батлагдсан 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Д.Сумаадагва)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6717010386